

Үндэсний статистикийн хорооны
даргын 2010 оны 5 дугаар сарын 27-
ны өдрийн 01/74 тоот тушаалын
хавсралт

БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦОХ АРГАЧЛАЛ

Улаанбаатар хот

2010 он

АГУУЛГА

- I. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**
- II. БҮТЭЭМЖ ТООЦОХОД АШИГЛАГДАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ**
- III. БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦОХОД БАРИМТЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР**
- IV. БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦОХ АРГА ЗҮЙ**
- V. ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦСОН БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ НИЙТЭД ТАРХААХ**

ХАВСРАЛТ – Бүтээмжийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх үнээр тооцсон жишээ

БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦОХ АРГАЧЛАЛ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Улс орнуудын хөгжлийн өмнө тавигддаг нэг шалгуур бол бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх явдал юм. Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд эдийн засгийн үр ашиг бүтээмжээр дамжин илэрдэг билээ.
- 1.2 Өнөөгийн практикаар Үндэсний статистикийн хороо нь нийт бүтээмж, үндсэн хүчин зүйлийн бүтээмж, тодорхой хүчин зүйлсийн бүтээмж (хөдөлмөр, капитал, түүхий эд, үндсэн материал, эрчим хүчний бүтээмж) гэсэн үндсэн 3 төрлийн бүтээмжийг Үндэсний статистикийн газрын даргын 2005 оны 6 сарын 06-ны өдрийн 01/68 тоот тушаалаар батлагдсан “Бүтээмж тооцох аргачлал”-ын дагуу оны үнээр, салбараар тооцож байна.
- 1.3 Бүтээмжийн бодит өсөлтийг харуулахын тулд бүтээмжийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх үнээр тооцох шаардлага тавигдаж байна. Бүтээмжийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх үнээр тооцоход ашиглагдах цалин, үндсэн хөрөнгийн элэгдэл, завсрын хэрэглээ зэрэг үзүүлэлтүүдийг одоогоор манай практикт зэрэгцүүлэх үнээр тооцоогүй байгаа юм. Иймд эдгээр үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх үнээр тооцдог болсноор орлогын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэх үнээр үнэлэх боломж бүрдэнэ.

ХОЁР. БҮТЭЭМЖ ТООЦОХОД АШИГЛАГДАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 **Нийт бүтээмж** нь бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор үйлдвэрлэлд зарцуулсан нийт зардлын нэг төгрөг тутмаас хэдэн төгрөгийн бүтээгдэхүүн бий болгосныг харуулах үзүүлэлт. Энэ үзүүлэлтийг салбараар тооцоход нэмэгдэл өртгийн хэмжээг (улсын түвшинд ДНБ) завсрын хэрэглээ, хөдөлмөр (цалин), капитал (үндсэн хөрөнгийн элэгдэл)-ийн нийлбэрт харьцуулж тооцно.

$$\text{Нийт бүтээмж} = \frac{\text{Нэмэгдэл өртгийн хэмжээ}}{(\text{Завсрын хэрэглээ} + \text{Цалин} + \text{Үндсэн хөрөнгийн элэгдэл})}$$

Үүнд:

2.1.1 **Нэмэгдэл өртөг** нь аж ахуйн нэгж, байгууллагын тухайн хугацааны нийт үйлдвэрлэлийн хэмжээнээс завсрын хэрэглээг хасч тооцсон үзүүлэлт юм. Нэмэгдэл өртөг нь цалин, хөлс, НДШ, ЭМД, үндсэн хөрөнгийн элэгдэл, онцгой болон бүтээгдэхүүний татвар, татаас, ашгаас бүрдэнэ.

2.1.2 **Завсрын хэрэглээ нь** үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахын тулд зарцуулсан материалын зардал болон үйлчилгээний төлбөр юм.

2.1.3 **Цалин хөлс** нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагаас үйлдвэрлэл явуулахад зарцуулсан хөдөлмөрийнх нь хувь хэмжээнд тохируулан ажиллагчиддаа мөнгөн болон биет хэлбэрээр олгодог нөхөн төлбөр юм.

2.1.4 **Үндсэн хөрөнгийн элэгдэл** нь тайлант хугацаанд ашиглагдсан үндсэн хөрөнгөөс байгуулсан элэгдлийн хэмжээ юм.

2.2 **Үндсэн хүчин зүйлийн бүтээмж** нь үйлдвэрлэлийн гол хүчин зүйлс болох хөдөлмөр, капиталын ашиглалтын үр ашгийг тодорхойлно. Үндсэн хүчин зүйлийн бүтээмжийг салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг (улсын түвшинд ДНБ) үндсэн хөрөнгийн элэгдэл болон ажиллагчдын цалин, хөлсний нийлбэрт харьцуулж тооцно.

$$\text{Үндсэн хүчин зүйлийн бүтээмж} = \frac{\text{Нэмэгдэл өртгийн хэмжээ}}{(\text{Ажиллагчдын цалин} + \text{Үндсэн хөрөнгийн элэгдэл})}$$

2.3 **Тодорхой нэг хүчин зүйлийн бүтээмжийг** тодорхой зардлын төрөл тус бүрээр хөдөлмөр, капитал, үндсэн түүхий эд, материал, эрчим хүчний бүтээмж гэж тооцно. Үүнд:

2.3.1 *Хөдөлмөрийн бүтээмж* нь үйлдвэрлэлийн гол хүчин зүйл болох хөдөлмөрийн үр ашгийг тодорхойлох бөгөөд нэг ажилтанд ногдох хөдөлмөрийн бүтээмжийг тооцохдоо салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг (улсын түвшинд ДНБ) ажиллагчдын жилийн дундаж тоонд хувааж тооцно. Түүнчлэн хөдөлмөрийн бүтээмжийг хүн цаг болон хүн өдрөөр тооцож болно.

$$\text{Хөдөлмөрийн бүтээмж} = \frac{\text{Нэмэгдэл өртгийн хэмжээ}}{\text{Ажиллагчдын жилийн дундаж тоо}}$$

2.3.2 *Капиталын бүтээмж* нь үйлдвэрлэлд ашигласан нэгж капиталаар бүтээгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ буюу үндсэн хөрөнгийн ашиглалтын түвшинг илэрхийлнэ. Капиталын бүтээмжийг тодорхойлохдоо салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг (улсын түвшинд ДНБ) үндсэн хөрөнгийн элэгдэлд харьцуулж тооцно.

$$\text{Капиталын бүтээмж} = \frac{\text{Нэмэгдэл өртгийн хэмжээ}}{\text{Үндсэн хөрөнгийн элэгдэл}}$$

2.3.3 *Түүхий эд, үндсэн материалын бүтээмж* нь үйлдвэрлэлд зарцуулсан үндсэн түүхий эд материалын үр ашгийг харуулах бөгөөд уг үзүүлэлтийг салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг (улсын түвшинд ДНБ) үндсэн түүхий эд материалын зардалд харьцуулж тооцно.

$$\text{Түүхий эд, үндсэн материалын бүтээмж} = \frac{\text{Нэмэгдэл өртгийн хэмжээ}}{\text{Түүхий эд, материалын зардал}}$$

2.3.4 Эрчим хүчний үр ашигтай, зохистой хэрэглээг эрчим хүчний бүтээмжийн үзүүлэлт илэрхийлэх бөгөөд эрчим хүчний бүтээмжийг тодорхойлохдоо салбарын нэмэгдэл өртгийн хэмжээг (улсын түвшинд ДНБ) эрчим хүчний зардалд харьцуулж тооцно. Эрчим

хүчний зардалд зөвхөн цахилгаан эрчим хүчний зардал орно.

$$\text{Эрчим хүчний бүтээмж} = \frac{\text{Нэмэгдэл өртгийн хэмжээ}}{\text{Эрчим хүчний зардал}}$$

- 2.4 **Зэрэгцүүлэх үнэ буюу суурь оны үнэ** гэдэг нь суурь болгож авсан тухайн нэг тодорхой “оны үнэ” байна. Тооцоонд ашиглагдах бүтээгдэхүүний зэрэгцүүлэх буюу суурь оны үнийг ҮСХ-ны даргын холбогдох шийдвэрээр баталгаажуулна.
- 2.5 Жин тооцсон үе нь индексийн тайлант үетэй давхцаж байдаг индексийг **Паашегийн үнийн индекс** гэнэ. Сагсан дахь бараа, үйлчилгээний тайлант болон суурь үеийн үнийн өөрчлөлтийг суурь үеийн нийт зардалд бараа, үйлчилгээний эзлэх хувийн жингээр жигнэж тооцсон индексийг **Ласпейресийн үнийн индекс** гэдэг.
- 2.6 **Дефлятор** гэдэг нь тухайн үзүүлэлтийн тайлант оны дүнг суурь буюу зэрэгцүүлэх оны дүнд харьцуулсан индекс юм.
- 2.7 **Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь** хэрэглэгчийн худалдаж авсан бараа болон үйлчлүүлсэн үйлчилгээний үнийн ерөнхий өөрчлөлтийг харуулах индекс юм.
- 2.8 **Барилгын өртгийн индекс** гэдэг нь барилгын материалын индекс, цалингийн индекс, механизмын индекс тус бүрийг тэдгээрийн нийт зардлын дүнд эзлэх хувийн жингээр жигнэж тооцсон индекс юм.
- 2.9 **Жижиглэн худалдааны үнийн индекс /ЖХҮИ/** нь худалдааны аж ахуйн нэгж, байгууллагаас хүн амын эцсийн хэрэглээнд зориулан борлуулдаг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.
- 2.10 **Завсрын хэрэглээний үнийн индекс** нь дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулахад зориулан худалдан авсан бараа бүтээгдэхүүний үнийн (худалдан авагчийн) өөрчлөлтийг илэрхийлнэ.
- 2.11 **Гадаад худалдааны импортын үнийн индекс** нь импортоор оруулж ирдэг бараа бүтээгдэхүүний үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

2.12 **Ажиллагчдын жилийн дундаж тоог** тайлант оны эхний болон эцсийн ажиллагчдын тооны арифметикийн дунджаар илэрхийлнэ. Хэрэв ажиллагчдын тооны өөрчлөлт хэлбэлзэл ихтэй бол жигнэсэн дунджийн эсвэл хронологийн дунджийн аргыг ашиглана.

ГУРАВ. БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦОХОД БАРИМТЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

3.1 Бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо тохиромжит үнийн индекс болон дефляторыг ашиглана гэсэн ерөнхий зарчмыг баримтална. Бүтээмжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар, зэрэгцүүлэх үнээр тооцох зарчим нь ерөнхий зарчимтай ижил байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн салбаруудын хувьд тооцооны зарчим нь улсын түвшний тооцоотой ижил байна.

3.2 Бүтээмжийн үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх үнээр тооцоход дараах мэдээллүүдийг ашиглана. Үүнд:

- Зэрэгцүүлэх үнээр тооцсон үйлдвэрлэлийн аргаарх ДНБ, салбараар, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Завсрын хэрэглээний дүн, оны үнээр, салбараар, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн хэмжээ, оны үнээр, салбараар, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Ажиллагчдын цалин, хөлсний хэмжээ, оны үнээр, салбараар, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн улсын индекс, бүлгээр, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Гадаад худалдааны импортын үнийн индекс, барааны бүлгээр, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Завсрын хэрэглээний үнийн индекс, салбараар, мэдээллийн мэдээллийн эх үүсвэр:ҮСХ

- Барилгын төсөвт өртгийн индекс, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Жижиглэн худалдааны үнийн индекс, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- ХАА-н бүтээгдэхүүний үнэ, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Ажиллагчдын жилийн дундаж тоо, салбараар, Ажиллах хүчний судалгаа, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Түүхий эд, үндсэн материалын зардлын дүн, оны үнээр, салбараар, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ
- Цахилгаан, эрчим хүчний зардлын дүн, оны үнээр, салбараар, мэдээллийн эх үүсвэр:ҮСХ

ДӨРӨВ. БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦОХ АРГА ЗҮЙ

4.1 *Нийт бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо* зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий хэмжээг капитал (үндсэн хөрөнгийн элэгдэл), хөдөлмөр (цалин хөлс), завсрын хэрэглээний дүнгийн нийлбэрт харьцуулна.

$$\text{Нийт бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{\text{ДНБ, зэрэгцүүлэх үнээр}}{(\text{Завсрын хэрэглээ, зэрэгцүүлэх үнээр} + \text{Цалин, зэрэгцүүлэх үнээр} + \text{Үндсэн хөрөнгийн элэгдэл, зэрэгцүүлэх үнээр})}$$

4.2 *Үндсэн хөрөнгийн элэгдлийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо* оны үнээрх үндсэн хөрөнгийн элэгдлийг үндсэн хөрөнгийн дараах бүрэлдэхүүн хэсгээр гаргаж, тохирох үнийн индекс, дефляторт хуваана. Үүнд:

4.2.1 *Барилга, байгууламжийн элэгдэл* – ийг үйлдвэрлэлийн аргын тооцооны барилгын төсөвт өртгийн индекс хувааж зэрэгцүүлэх үнээр үнэлнэ. Барилгын төсөвт өртгийн индексийг тооцоогүй тохиолдолд барилгын салбарын нэмэгдэл өртгийн дефляторт хувааж тооцно.

4.2.2 *Тээврийн хэрэгслийн элэгдэл* - ийг гадаад худалдааны авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгслийн бүлгийн импортын үнийн индекст хувааж, зэрэгцүүлэх үнээр тооцно.

4.2.3 *Машин, тоног төхөөрөмжийн элэгдэл* – ийг гадаад худалдааны машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, телевизийн сэлбэг, эд ангийн бүлгийн импортын үнийн индекст хувааж, зэрэгцүүлэх үнээр тооцно.

4.3 *Ажиллагчдын цалин, хөлсний хэмжээг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо* оны үнээрх цалин, хөлсний хэмжээг хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ)-д хуваана.

4.4 *Завсрын хэрэглээг зэрэгцүүлэх үнээр тооцох* ерөнхий зарчим нь салбар бүрийн оны үнээрх завсрын хэрэглээний дүнг салбар бүрийн завсрын хэрэглээний үнийн индекст хуваах явдал юм. Завсрын хэрэглээний үнийн индексийн мэдээлэл байхгүй тохиолдолд тухайн салбарын үйлдвэрлэлийн зардлын онцлогийг харгалзан салбар бүрийн хувьд дараах дефлятор, индексийг ашиглана. Үүнд:

- *Хөдөө аж ахуйн салбарын хувьд* завсрын хэрэглээг мал аж ахуйн болон газар тариалангийн салбараар нь задалж зэрэгцүүлэх үнээр тооцно. Мал аж ахуйн салбарын хувьд малын тэжээл, газар тариалангийн салбарын тухайд шатахуун, сэлбэг хэрэгсэл, бордоо нь завсрын хэрэглээний дийлэнхи хувийг бүрдүүлдэг тул эдгээр бараа, бүтээгдэхүүний үнийн индексийг ашиглаж зэрэгцүүлэх үнээр тооцно.
- *Аж үйлдвэрийн салбарын хувьд* тухайн дэд салбар бүрийн завсрын хэрэглээг холбогдох дэд салбарын (уул уурхай, олборлох үйлдвэр, боловсруулах үйлдвэр, цахилгаан, дулаан, эрчим хүч, усан хангамжийн салбар) нийт үйлдвэрлэлийн дефляторт хувааж, зэрэгцүүлэх үнээр тооцно.

- *Барилгын салбарын хувьд* тухайн салбарын оны үнээрх завсрын хэрэглээг барилгын төсөвт өртгийн индекст хувааж, зэрэгцүүлэх үнээр тооцно. Барилгын төсөвт өртгийн индексийн мэдээлэл байхгүй тохиолдолд ХҮУИ-ийн барилгын гол нэр төрлийн материалын үнийн индекс буюу барилгын засварын материалын дэд бүлгийн үнийн индексийг ашиглана.
- *Тээвэр, агуулахын аж ахуй, холбооны салбарын хувьд* оны үнээрх завсрын хэрэглээг ХҮУИ-ийн тээвэр, холбооны бүлгийн үнийн индекст хувааж, зэрэгцүүлэх үнээр тооцно.
- *Бусад салбаруудын хувьд* тухайн салбаруудын оны үнээрх завсрын хэрэглээний дүнг хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн улсын индекст хувааж, зэрэгцүүлэх үнээр тооцно.
- *Улсын түвшинд* завсрын хэрэглээг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо салбар бүрийн зэрэгцүүлэх үнээр үнэлсэн завсрын хэрэглээний үнийн дүнгийн нийлбэрээр авна.

4.5 *Үндсэн хүчин зүйлийн бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо* зэрэгцүүлэх үнээр үнэлсэн салбарын нэмэгдэл өртгийг үндсэн хөрөнгийн элэгдэл болон ажиллагчдын цалин, хөлсний хэмжээнд хуваана.

$$\text{Үндсэн хүчин зүйлийн бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{\text{ДНБ, зэрэгцүүлэх үнээр}}{(\text{Цалин, зэрэгцүүлэх үнээр} + \text{Үндсэн хөрөнгийн элэгдэл, зэрэгцүүлэх үнээр})}$$

4.6 *Хөдөлмөрийн бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо* зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ийг ажиллагчдын жилийн дундаж тоонд хуваана.

$$\text{Хөдөлмөрийн бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{\text{ДНБ, зэрэгцүүлэх үнээр}}{\text{Ажиллагчдын жилийн дундаж тоо}}$$

4.7 *Капиталын бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ийг үндсэн хөрөнгийн элэгдлийн хэмжээнд хуваана.*

$$\text{Капиталын бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{\text{ДНБ, зэрэгцүүлэх үнээр}}{\text{Үндсэн хөрөнгийн элэгдэл, зэрэгцүүлэх үнээр}}$$

4.8 *Түүхий эд, үндсэн материалын бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ийг үндсэн түүхий эд, материалын зардлын хэмжээнд хуваана.*

$$\text{Түүхий эд, үндсэн материалын бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{\text{ДНБ, зэрэгцүүлэх үнээр}}{\text{Түүхий эд, материалын зардал, зэрэгцүүлэх үнээр}}$$

4.8.1 *Түүхий эд, үндсэн материалын зардлыг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо оны үнээрх нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан түүхий эд, үндсэн материалын зардлыг аж үйлдвэрийн салбарын боловсруулах үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн дефляторт хуваана.*

4.9 *Эрчим хүчний бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ийг эрчим хүчний зардалд хуваана. Мөн зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ийг тухайн жилд хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний нийт биет хэмжээнд хувааж тооцож болно.*

$$\text{Эрчим хүчний бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{\text{ДНБ, зэрэгцүүлэх үнээр}}{\text{Эрчим хүчний зардал, зэрэгцүүлэх үнээр}}$$

4.9.1 *Эрчим хүчний зардлыг зэрэгцүүлэх үнээр тооцохдоо тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний зардлыг ХҮҮИ-ийн цахилгаан эрчим хүчний үнийн индекст хуваана.*

Тав. Зэрэгцүүлэх үнээр тооцсон бүтээмжийн үзүүлэлтийг нийтэд тархах

5.1 Тус аргачлалын 4.1, 4.5, 4.6, 4.7, 4.8, 4.9-д заасан, зэрэгцүүлэх үнээр тооцсон бүтээмжийн үзүүлэлтүүдийг нийтэд тархахдаа улсын түвшин, салбараар тооцож жил бүрийн статистикийн эмхтгэлд оруулж тархаана.

**Бүтээмжийн үзүүлэлтүүдийг
зэрэгцүүлэх үнээр тооцсон жишээ**

Нэг. Нийт бүтээмжийн зэрэгцүүлэх үнийн тооцоо

Аргачлалд дурьдсанаар зэрэгцүүлэх үнээр үнэлсэн ДНБ-ий хэмжээг нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан нийт завсрын хэрэглээ, цалин, үндсэн хөрөнгийн элэгдлийн нийлбэрт харьцуулж, нийт бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцох бөгөөд үүнийг хэрхэн тооцохыг дараах жишээгээр харуулъя.

Хүснэгт 1-д тайлант оны үнээрх нийт бүтээмжийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн мэдээлэл болон ДНБ-ий хэмжээ суурь буюу 2005 оны үнээр өгөгдсөн гэж үзье.

Хүснэгт 1.

Үзүүлэлт	Үнийн дүн /сая төг/	
	Оны үнээр	2005 оны үнээр
ДНБ	3 714 952.9	3 017 425.8
Завсрын хэрэглээ	3 461 469.8	<i>ЗХ₂₀₀₅</i>
Нийт цалин	760 418.3	<i>НЦ₂₀₀₅</i>
Үндсэн хөрөнгийн элэгдэл	241 281.7	<i>ҮХЭ₂₀₀₅</i>

Хүснэгт 1-д ДНБ-ий хэмжээ суурь буюу 2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцогдсон байгаа учир завсрын хэрэглээ (*ЗХ₂₀₀₅*), нийт цалин (*НЦ₂₀₀₅*), үндсэн хөрөнгийн элэгдлийг (*ҮХЭ₂₀₀₅*) 2005 оны үнээр тооцно. Ингэхдээ:

I. Завсрын хэрэглээг (улсын дүн) зэрэгцүүлэх үнээр тооцоходоо юуны өмнө эхлээд салбар бүрийн завсрын хэрэглээг зэрэгцүүлэх үнээр үнэлнэ. Салбаруудын зэрэгцүүлэх үнээрх завсрын хэрэглээний дүнгийн нийлбэр нь улсын түвшний завсрын хэрэглээний дүн болно (Хүснэгт 2).

Үзүүлэлт	Үнийн дүн /сая төг/			
	Оны үнээр	Холбогдох дефлятор, индекс		2005 оны үнээр
Завсрын хэрэглээ	3 461 469.8			3 084 142.9 (салбаруудын дүн)
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	269 818.6			253 827.8
МАА	202 364.0	105.0	Малын тэжээлийн үнийн индекс	192 727.6
Газар тариалан	67 454.7	110.4	Шатахууны үнийн индекс	61 100.2
Аж үйлдвэр	987 034.2			780 859.8
Уул уурхай, олборлох үйлдвэр	514 988.8	148.9	Уул уурхай, олборлох салбарын нийт үйлдвэрлэлийн дефлятор	345 796.6
Боловсруулах үйлдвэр	359 898.4	114.1	Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлийн дефлятор	315 523.8
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	112 146.9	93.8	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын нийт үйлдвэрлэлийн дефлятор	119 539.4
Барилга	229 403.2	108.7	Хэрэглээний үнийн улсын индексийн барилгын засварын материалын дэд бүлгийн үнийн индекс	211 042.5
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	175 693.6	106.0	Хэрэглээний үнийн улсын индекс	165 748.7
Зочид буудал, зоогийн газар	48 115.6	106.0	Хэрэглээний үнийн улсын индекс	45 392.1
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	486 923.5	112.1	Хэрэглээний үнийн улсын индексийн тээвэр, холбооны бүлгийн үнийн индекс	434 365.3
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	191 953.5	106.0	Хэрэглээний үнийн улсын индекс	181 088.2
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	213 101.5	106.0	Хэрэглээний үнийн улсын индекс	201 039.2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	655 154.4	106.0	Хэрэглээний үнийн улсын индекс	618 070.2
Боловсрол	79 919.7	106.0	Хэрэглээний үнийн улсын индекс	75 395.9
Эрүүл мэнд, нийгмийн халамж	54 892.8	106.0	Хэрэглээний үнийн улсын индекс	51 785.7
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	69 459.1	106.0	Хэрэглээний үнийн улсын индекс	65 527.4

$$3X_{2005} = 3\,084\,142.9$$

I. Нийт цалинг зэрэгцүүлэх үнээр тооцъё. Тайлант оны байдлаар ХҮУИ=106.0 байгаа, эндээс:

$$HC_{2005} = \frac{\text{Нийт цалин, оны үнээр}}{\text{Хэрэглээний үнийн улсын индекс}} * 100 = \frac{760\,418.3}{106.0} * 100 = 717\,375.8$$

II. Үндсэн хөрөнгийн нийт элэгдлийг зэрэгцүүлэх үнээр үнэлье. Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийг барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл гэсэн бүтцээр нь гаргахдаа тухайн оны үндсэн хөрөнгийн элэгдлийн улсын дүнгийн бүтцийг (Сангийн Яамнаас нэгтгэдэг аж ахуйн нэгж, байгууллагын тайлан, балансын нэгтгэл) ашиглаж тооцоолол хийнэ.

$$\begin{aligned} YX_{2005} &= \frac{\text{Үндсэн хөрөнгийн элэгдэл, оны үнээр}}{\text{Тохирох харгалзах индекс, дефлятор}} \\ &= \left(\frac{\text{Барилга, байгууламжийн элэгдэл, оны үнээр}}{\text{Барилгын салбарын нэмэгдэл өртгийн дефлятор}} + \frac{\text{Машин, тоног төхөөрөмжийн элэгдэл, оны үнээр}}{\text{Гадаад худалдааны машин, тоног төхөөрөмжийн бүлгийн импортын үнийн индекс}} + \frac{\text{Тээврийн хэрэгслийн элэгдэл, оны үнээр}}{\text{Гадаад худалдааны авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгслийн бүлгийн импортын үнийн индекс}} \right) \end{aligned}$$

Манай жишээгээр тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн улсын дүнгийн мэдээллээр тухайн оны үндсэн хөрөнгийн элэгдлийн 36.9 хувь нь барилга байгууламжид, 35.6 хувь нь машин, тоног төхөөрөмжид, 27.5 хувь нь тээврийн хэрэгсэлд ногдож байна гэж үзье.

Тайлант оны байдлаар *барилгын салбарын нэмэгдэл өртгийн дефлятор=102.2*, *гадаад худалдааны машин, тоног төхөөрөмжийн бүлгийн импортын үнийн индекс=150.2*, *авто, агаарын ба усан замын тээврийн бүлгийн импортын үнийн индекс=89.9* байгаа бол эндээс эдгээр бүтцийг ашиглан үндсэн хөрөнгийн элэгдлийг зэрэгцүүлэх үнээр тооцоолбол (Хүснэгт 3):

Үзүүлэлт	Үнийн дүн /сая төг/		
	Оны үнээр	Холбогдох дефлятор, индекс	2005 оны үнээр
Үндсэн хөрөнгийн элэгдэл	241 281.8		218 111.4
Барилга, байгууламж	89 033.0	102.2	87 116.44
Машин, тоног төхөөрөмж	85 896.3	150.2	57 187.95
Тээврийн хэрэгсэл	66 352.5	89.9	73 807.01

$$YXЭ_{2005} == \left(\frac{89\,033.0}{102.2} * 100 + \frac{85\,896.3}{150.2} * 100 + \frac{66\,352.5}{89.9} * 100 \right)$$

$$YXЭ_{2005} = 218\,111.4$$

III. Нийт бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцоолбол:

$$Нийт\ бүтээмж = \frac{ДНБ, 2005\ оны\ үнээр}{(ЗХ_{2005} + НЦ_{2005} + YXЭ_{2005})} = \frac{3\,017\,425.8}{(3\,084\,142.9 + 717\,375.8 + 218\,111.4)}$$

$$Нийт\ бүтээмж = \frac{3\,017\,425.8}{4\,019\,630.1} = 0.75$$

Тухайн тайлант онд 2005 оны үнээр нийт бүтээмж 0.75 төг болж, өмнөх оныхоос (өмнөх онд 0.80 төг байсан гэвэл) 0.05 төгрөгөөр буурчээ гэсэн үр дүн гарч байна.

Хоёр. Үндсэн хүчин зүйлийн бүтээмжийн зэрэгцүүлэх үнийн тооцоо

Өмнөх жишээнд үндэслэн үндсэн хүчин зүйлийн бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцъё. Аргачлалд дурьдсанаар зэрэгцүүлэх үнээрх ДНБ-ий хэмжээг нэмэгдэл өртгийг бий болгоход зарцуулсан нийт цалин, үндсэн хөрөнгийн элэгдлийн нийлбэрт харьцуулж, үндсэн хүчин зүйлийн бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцно.

$$Үндсэн\ хүчин\ зүйлийн\ бүтээмж,\ зэрэгцүүлэх\ үнээр = \frac{3\,017\,425.8}{(717\,375.8 + 218\,111.4)} = 3.2$$

Тухайн тайлант онд 2005 оны үнээр үндсэн хүчин зүйлийн бүтээмж 3.2 төг болж, өмнөх оныхоос (өмнөх онд 3.6 төг байсан гэвэл) 0.4 төгрөгөөр буурчээ гэсэн үр дүн гарч байна.

Гурав. Тодорхой хүчин зүйлийн бүтээмжийн зэрэгцүүлэх үнийн тооцоо

Мөн өмнөх жишээнд үндэслэн тодорхой хүчин зүйлийн бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцье. Аргачлалд дурьдсанаар тодорхой хүчин зүйлийн бүтээмжийг зардлын 4 төрлөөр тооцно. Үүнд:

3.1 Хөдөлмөрийн бүтээмж

Аргачлалд дурьдсанаар зэрэгцүүлэх үнээрх ДНБ-ий хэмжээг ажиллагчдын жилийн дундаж тоонд харьцуулж, хөдөлмөрийн бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцно.

Тайлант оны байдлаар ажиллагчдын жилийн дундаж тоо 989.1 мянга байсан гэвэл;

$$\text{Хөдөлмөрийн бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{3\,017\,425.8}{989.1} = 3050.7$$

Тухайн тайлант онд 2005 оны үнээр хөдөлмөрийн бүтээмж 3050.7 төг болж, өмнөх оныхоос (өмнөх онд 2897.2 төг байсан гэвэл) 153.5 төгрөгөөр нэмэгджээ гэсэн үр дүн гарч байна. Өөрөөр хэлбэл нэг ажилтанд ногдох хөдөлмөрийн бүтээмж өссөн байна.

3.2 Капиталын бүтээмж

Аргачлалд дурьдсанаар зэрэгцүүлэх үнээрх ДНБ-ий хэмжээг үндсэн хөрөнгийн элэгдэлд харьцуулж, капиталын бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцно.

$$\text{Капиталын бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{3\,017\,425.8}{218\,111.4} = 13.8$$

Тухайн тайлант онд 2005 оны үнээр капиталын бүтээмж 13.8 төг болж, өмнөх оныхоос (өмнөх онд 15.6 төг байсан гэвэл) 1.8 төгрөгөөр буурчээ гэсэн үр дүн гарч байна.

3.3 Түүхий эд, үндсэн материалын бүтээмж

Аргачлалд дурьдсанаар зэрэгцүүлэх үнээрх ДНБ-ий хэмжээг түүхий эд, үндсэн материалын зардалд харьцуулж, түүхий эд, үндсэн материалын бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцно.

Тайлант оны байдлаар түүхий эд, үндсэн материалын зардал 735 855.3 сая төг, аж үйлдвэрийн боловсруулах салбарын нийт үйлдвэрлэлийн дефлятор 114.1 байсан гэвэл;

$$\text{Түүхий эд, үндсэн материалын зардал, зэрэгцүүлэх үнээр} = \frac{735\,855.3}{114.1} * 100 = 644921.4$$

Эндээс:

$$\text{Түүхий эд, үндсэн материалын бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{3\,017425.8}{644921.4} = 4.7$$

Тухайн тайлант онд 2005 оны үнээр түүхий эд, үндсэн материалын бүтээмж 4.7 төг болж, өмнөх оныхоос (өмнөх онд 4.2 төг байсан гэвэл) 0.5 төгрөгөөр өсчээ гэсэн үр дүн гарч байна.

3.4 Эрчим хүчний бүтээмж

Аргачлалд дурьдсанаар зэрэгцүүлэх үнээрх ДНБ-ий хэмжээг цахилгаан эрчим хүчний зардалд харьцуулж, эрчим хүчний бүтээмжийг зэрэгцүүлэх үнээр тооцно.

Тайлант оны байдлаар цахилгаан эрчим хүчний зардал 126 157.9 сая төг, ХҮҮИ-ийн цахилгаан эрчим хүчний үнийн индекс 103.0 байсан гэвэл;

$$\text{Эрчим хүчний зардал, зэрэгцүүлэх үнээр} = \frac{126157.9}{103.0} * 100 = 122\,483.4$$

Эндээс:

$$\text{Эрчим хүчний бүтээмж, зэрэгцүүлэх үнээр} = \frac{3\,017425.8}{122\,483.4} = 24.6$$

Тухайн тайлант онд 2005 оны үнээр эрчим хүчний бүтээмж 24.6 төг болж, өмнөх оныхоос (өмнөх онд 27.1 төг байсан гэвэл) 2.5 төгрөгөөр буурчээ гэсэн үр дүн гарч байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

-----oO-----